



САЛБАР ХУРАЛДААНЫ ҮР ДҮН

Ц.ЭРДЭМБИЛЭГ
Эрүүл мэндийн яамны
Төрийн нарийн бичгийн дарга



1. ЭХ БАРИХ, ЭМЭГТЭЙЧҮҮД, ХҮҮХДИЙН САЛБАРЫН ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

Модератор: Ж.Нарангэрэл, ЭМЯ-ны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын дарга

2. НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЬЕ

Модератор: Б.Баярболд, Нийтийн эрүүл мэндийн газрын дарга

3. СУВИЛАХУЙН ТУСЛАМЖИЙН ШИНЭЧЛЭЛ, СУВИЛАГЧ МЭРГЭЖЛИЙН ҮНЭ ЦЭНЭ

Модератор: П.Эрхэмбаяр, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга

4. ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ, ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭ, ХЭРЭГЖИЛТ

Модератор: Б.Буянтогтох, Бодлого, төлөвлөлтийн газрын дарга

5. ХАВДРЫН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Модератор: С.Төгсдэлгэр, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга

6. ЭРҮҮЛ МЭНДИЙН САНХҮҮЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Модератор: Б.Мөнхтуул, ЭМЯ-ны Санхүү, эдийн засгийн газрын дарга

САЛБАР ХУРАЛДААН – 1. ЭХ БАРИХ, ЭМЭГТЭЙЧҮҮД, ХҮҮХДИЙН САЛБАРЫН ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ



Хэлэлцүүлсэн илтгэл:

1. Хувь хүний хөгжил илтгэл
2. Эх, хүүхдийн эрүүл мэндийн чиглэлээр баримталж буй бодлого, чиглэл
3. Эх, хүүхдийн эндэгдлийн өнөөгийн байдал; Эх, хүүхдийн тусламж үйлчилгээнд олон нийтийн оролцоо

САЛБАР ХУРАЛДААН – 2. НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЬЕ!



Хэлэлцүүлсэн илтгэл:

1. Хувь хүний хөгжил сургалт
2. Нийгмийн эрүүл мэндийн ирээдүйн чиг хандлага
3. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр 2022 оны хэрэгжүүлэх үйл ажиллагаанд Нийслэлийн эрүүл мэндийн газрын оролцоо,

50 гаруй байгууллагын 90 удирдах албан тушаалтан 9 багт хуваагдан ажиллав.

САЛБАР ХУРАЛДААН – 3. СУВИЛАХУЙН ТУСЛАМЖИЙН ШИНЭЧЛЭЛ, СУВИЛАГЧ МЭРГЭЖЛИЙН ҮНЭ ЦЭНЭ



Хэлэлцүүлсэн илтгэл:

1. Төгсөлтийн дараах сургалтын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага
2. Сувилахуйн тусламжийн өнөөгийн байдал, олон улсын чиг хандлага”

Хуралд төрөлжсөн эмнэлэг, Эрүүл мэндийн байгууллагын захирал, дарга нар, сувилахуйн тусламж хариуцсан мэргэжилтнүүд нийт 74 хүн оролцсон.

САЛБАР ХУРАЛДААН – 4.


ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ, ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭ, ХЭРЭГЖИЛТ



Хэлэлцүүлсэн илтгэл:

1. Хувь хүний хөгжлийн сургалт
2. Эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмжийн бодлогын арга хэмжээ, хэрэгжилт
3. Эм, зүйн албаны чиг хандлага, сайн туршлага

САЛБАР ХУРАЛДААН – 5. ХАВДРЫН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ НЬ



Хэлэлцүүлсэн илтгэл:

1. Хувь хүний хөгжлийн сургалт
2. Хорт хавдрын тусламж үйлчилгээний төвлөрлийг сааруулах нь
3. Хорт хавдрын, эрт илрүүлгийн тогтолцоог бэхжүүлэх нь

50 гаруй байгууллагын 95 удирдах албан тушаалтан 9 багт хуваагдан ажиллав.

САЛБАР ХУРАЛДААН – 6. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН САНХҮҮЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ



Хэлэлцүүлсэн илтгэл:

1. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн бодлого, шинэчлэл
2. Стратегийн худалдан авалтыг бий болгож буй үйл явц, гэрээлэлт, хяналт
3. Төрийн болон орон нутгийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэл, тайлагналтад анхаарах асуудлууд
4. Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн танилцуулга

САЛБАР ХУРАЛДААНААС ГАРСАН САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. ЭХ БАРИХ, ЭМЭГТЭЙЧҮҮД, ХҮҮХДИЙН САЛБАРЫН ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ - **25**
2. НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЬЕ - **26**
3. СУВИЛАХУЙН ТУСЛАМЖИЙН ШИНЭЧЛЭЛ, СУВИЛАГЧ МЭРГЭЖЛИЙН ҮНЭ ЦЭНЭ - **30**
4. ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ, ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭ, ХЭРЭГЖИЛТ - **38**
5. ХАВДРЫН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ - **66**
6. ЭРҮҮЛ МЭНДИЙН САНХҮҮЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ - **24**


Нийт **209** санал, зөвлөмж гаргасныг дараах 5 чиглэлээр багцлан танилцуулж байна.

- Эрхзүйн орчин, тогтолцоог боловсронгуй болгох
- Тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх
- Хүний нөөцийн чадавхийг сайжруулах
- Салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах
- Санхүүжилтийг нэмэгдүүлэх

- Эх, хүүхдийн эрүүл мэндийн тухай хууль батлуулах;
- Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль батлуулах;
- Гамшгаас хамгаалах тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Тусгай зөвшөөрлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулинд гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн зохицуулалтыг оруулах
- Аймаг, нийслэлийн түвшинд эмнэлгийн зохион байгуулалтыг оновчтой болгох, тусгай зөвшөөрлийг хүн амын хэрэгцээний үнэлгээнд суурилан олгодог болох.
- Эмнэлгийн бие даасан байдлыг хангахад оролцогч талуудын чиг үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, ТУЗ-ийн зохицуулалтыг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах
- Хорт хавдрын тусламж үйлчилгээг үзүүлэх эрхзүйн орчинг сайжруулах
- Хавдраас сэргийлэх, хянах хөтөлбөр боловсруулах батлах
- Өвчний хяналт, сэргийлэлтийн төв байгуулах
- Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулах
- Баруун бүсийн туяа эмчилгээний төв байгуулах

- НЭМ-ийн тусламж, үйлчилгээний стандарттай болох;
- Иргэн бүрийг, хүүхдийг эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд хамруулах ажлыг эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг доголдуулахгүйгээр зохион байгуулах
- Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох, ерөнхий боловсролын сургуулийн “Эрүүл мэндийн боловсрол” хичээлийн чанар, хүртээмж, хүний нөөцийн чадавхийг сайжруулах;
- НЭМ-ийн тайван цагийн болон ноцтой байдлын үеийн хариу арга хэмжээнд шаардлагатай хүний нөөц, эм эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж, шаардагдах хөрөнгө, нөөцийн төлөвлөлтийг сайжруулж, хариу арга хэмжээнд бэлэн байх;
- НЭМ-ийн тусламж үйлчилгээг анхан шатны түвшинд нэмэгдүүлэх
 - Жирэмсний хяналтын нэгдсэн тогтолцоотой болох (Хөдөлгөөнт хүн ам их тул жирэмсний хяналтыг чанар, хүртээмжтэй болгох, эрсдэлтэй жирэмсний хяналтыг сайжруулах);
 - Эх, нярайн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг чанаржуулах
 - Эм, биобэлдмэл, оношлуурыг шинжлэх лабораторийн чадавхи, чанарын хяналтыг сайжруулах, аюулгүй байдлын тандалт судалгааг эрчимжүүлэх, олон улсын стандарт, баримт бичгийг нутагшуулах;

- ЭМС-ын 2015 оны А/351 тушаалыг шинэчлэн аймаг, нийслэлийн хавдрын тусламж үйлчилгээний журам (хавдрын тасаг, кабинетийн хүний нөөц, орны тоо, үзүүлэх тусламж үйлчилгээний жагсаалт г.м)-ыг шинэчлэн батлах
- Тусламж үйлчилгээний стандартыг шинэчлэх, шинээр боловсруулах
- Орон нутагт хавдрын тасаг, хавдрын орны тоог нэмэгдүүлэх
- Хими эмчилгээний эмийн чанар, тасралтгүй хангалтыг сайжруулах, хими эмчилгээг орон нутагт хийх
- Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний журам шинэчлэх, хүний нөөцийг чадавхижуулах
- Дүрс оношилгоонд PACS систем нэвтрүүлэх
- Хавдрын мэс заслыг бүсчлэн хөгжүүлэх Зонхилон тохиолдох хорт хавдрын өвчлөл, нас баралтыг 2025 он хүртэл 20 хувиар бууруулах, зорилго тавих ажиллах
 - Эмнэлгүүд болон мэдээлэлийн технологийн компаниудын нягт хамтын ажиллагааг хангах, мөн өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагуудыг цахимжуулах
 - Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн нэгдсэн цахим сүлжээг бий болгох



ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХИЙГ САЙЖРУУЛАХ

- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг эмч, мэргэжилтнүүдийн тасралтгүй сургалтын нэгдсэн хөтөлбөртэй болох;
- Хөдөө орон нутагт нарийн мэргэжлийн эмч, мэргэшсэн эх баригч, багийн эмчийг бэлтгэх, орон тоогоор ажиллуулах;

Сувилагчийн хомсдолоос гаргахын тулд

- Нэг сувилагчид ноогдох үйлчлүүлэгчийн тоог бууруулах
 - Эмч сувилагчийн харьцаа 1:1 байгааг Улсын стандартад нийцүүлж 1:2 болгох
 - Ажлын ачаалалыг бууруулах/ Анхан шатны бичиг баримтыг хөтлөлтийг цахимжуулж, ээлжийн ажиллах цагийг багасгах, 8/16 –г 8/8/8 болгох
 - Туслах сувилагчийг ажиллуулах (4 сувилагч:1туслах сувилагч)
-
- НЭМ-ийн хүний нөөцийн бодлого боловсруулах, сургалтын хэрэгцээг тодорхойлж, чадавхжуулах;
 - Эрүүл мэндийн ажилтны хөрвөх чадварыг сайжруулах, багаар бэлтгэх;
 - Эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн манлайлал, удирдах чадвар, нөлөөллийг нэмэгдүүлэх;
 - Эмч солилцоо, урамшууллын тогтолцоо, тэтгэлэгт хөтөлбөр
 - Орон нутгийн эрүүл мэндийн сэтгэл зүйчийг мэргэшүүлэх
 - Анагаахын сургуульд элсэгчдийн тоонд хязгаар тавих, квот тогтоох



- Гэр бүл төлөвлөлтийн чиглэлд төрийн бус байгууллага, орон нутгийн удирдлагын дэмжлэг авах
- Цалинтай ээж хөтөлбөрийн мөнгийг нэмэх
- Эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын нийгмийн хамгааллын байдлыг сайжруулж, цалин урамшууллыг нэмэх, цалингийн шатлал ахиулах
- Орон сууцанд хамрагдахад дэмжлэг үзүүлэх
 - Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлд нийгмийн бүх салбарын байгууллагыг оролцуулах
 - Эмнэлгийн байгууллагын дэргэд эмч, сувилагч, ажилчдын хүүхдийн цэцэрлэг, өдөр өнжүүлэх төв байгуулах
 - Нийгмийн бүх салбарын бодлого, чиглэлд НЭМ-ийн тусламж үйлчилгээний бодлогыг тусгах;
 - Олон улс, донор байгууллагатай хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, тайлагналтыг ил тод болгох, үр дүнг бодлогын шийдвэрт ашиглах;
 - Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хувь хүний хариуцлага, оролцоог нэмэгдүүлэх;
 - Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ зорилтот болон өвөрмөц бүлэгт тохирсон байхаар зохион байгуулах;
 - НЭМ-ийн ноцтой байдлын үед дайчлан ажиллах сайн дурын ажилтан, үе тэнгийнхнийг бэлтгэх, чадавхжуулах.

САНХҮҮЖИЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

- Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг нэр, төрлөөр өртөгжүүлэх;
- НЭМ-ийн эрэлтэд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бий болгох, гүйцэтгэлийн санхүүжилт, зарцуулалт, тайлагналтыг хянах;
- НЭМ-ийн чиглэлээр ажиллаж байгаа төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн сүлжээ, хэмжээг тэгшитгэх, нийгмийн баталгааг сайжруулах;
- Бүх түвшинд хариу арга хэмжээний нөөцийг бүрдүүлэх, шинэчлэх;
- Урамшуулал, илүү цаг, нөхөн олговрыг цаг тухайд нь бүрэн олгох
- Арга хэмжээний төлөвлөгөө хэрэгжүүлэх санхүүжилтийг жил бүрийн улсын төсөвт суулгах
- ЭМД-ын сангаас санхүүждэггүй тусламж, үйлчилгээний санхүүжилтийг холбогдох төрийн байгууллагуудтай хэлэлцэн шийдүүлэх
- Хөрөнгө оруулалтыг бодит тооцоо, эдийн засгийн үнэлгээн дээр үндэслэн хийх
- Оношийн хамааралтай бүлгийн тарифыг эмнэлзүйн хүндрэлийн зэргээр нь ангилах, сайжруулах
- Өндөр өртөгтэй багаж тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний асуудлыг нэгдсэн байдлаар журамлах, орон нутагт өндөр өртөгтэй тоног төхөөрөмж нийлүүлэгдэж байгаа учраас засвар үйлчилгээний зардлыг төвлөрсөн байдлаар тендер хийж шийдэх
- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулга, засвар үйлчилгээ болон шинэ дэвшилтэт техник, технологийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд нэвтрүүлэх хөрөнгийн сан үүсгэх;

АНХААРЧ СОНСЪЁ...
АНЗААРЧ ӨӨРЧИЛЬЕ...
АЖИЛ ХЭРЭГЧЭЭР ХАНДЬЯА...